



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 17 өдөр

Дугаар А/Ч/11

Арвайхээр

Түр зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.г, л заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн саналыг харгалзан аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл бүхий үйлчилгээний газруудад тогтоосон цагийн хуваарийн дагуу 2020 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн "Баасан" гарагт архи, согтууруулах ундаагаар үйлчлэхийг түр зөвшөөрсүгэй.

2.Дээрх тусгай зөвшөөрөл бүхий үйлчилгээний газруудад хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газар (О.Ганбат), аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн)-нд тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100919